



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2024.03.15 № 467
танай _____-ны № _____-т

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ
ИНСТИТУТ ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Р.АМАРТҮВШИН ТАНАА

Хот төлөвлөлт, судалгааны институт
ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан,
гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт 19 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002033533



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/18/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024он	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com Ахлах аудитор Ч.Замбага Утас: 99127118 Аудитор: П.Саранчимэг Утас: 89986879
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 468
танай _____-ны № _____-т

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ,
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Р.АМАРТҮВШИН
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус ОНӨААТҮГ тайлант онд нийт 3,179.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 13,007.0 сая, бусад орлого 11.8 сая нийт 13,019.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 4.1 дахин давуулан биелүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус хэлтсийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 4 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 158.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022.12.31	2023.12.31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	771,975,598.27	4,806,480,088.88
1.1.02	Дансны авлага	643,859,653.98	490,998,615.98
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	15,781,049.91	292,126,062.18
1.1.04	Бусад авлага	436,182.58	-
1.1.06	Бараа материал	55,593,164.07	57,758,205.65
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	824,998.39	6,639,542.04
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,488,470,647.20	5,654,002,514.73
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	257,284,298.54	288,976,938.41
1.2.02	Биет бус хөрөнгө	2,208,000.00	2,981,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	259,492,298.54	291,958,738.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,747,962,945.74	5,945,961,253.14
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	313,496,400.00	3,551,065,056.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	-	572,727,272.73
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	313,496,400.00	4,123,792,328.73
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	313,496,400.00	4,123,792,328.73
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	161,153,013.31	161,153,013.31
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,273,313,532.43	1,661,015,911.10
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	462,936,014.15
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,273,313,532.43	1,198,079,896.95
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,434,466,545.74	1,822,168,924.41
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,747,962,945.74	5,945,961,253.14

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022.12.31	2023.12.31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	2,708,423,406.21	13,007,510,144.82
02	Борлуулалтын өртөг	1,720,964,345.29	11,579,215,548.83
03	Нийт ашиг(алдагдал)	987,459,060.92	1,428,294,595.99
05	Хүүний орлого	-	11,753,151.69
09	Борлуулалт, маркетингийн зардал	140,236,456.57	180,943,172.09
10	Ерөнхий ба удирдлагын зардал	679,698,566.37	734,701,902.24
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,038,582.13	565,858.78
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(18,149,169.92)	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	(10,595,182.98)
17.1	Олз, гарзын дүн	(16,110,587.79)	(10,029,324.20)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	151,413,450.19	514,373,349.15
19	Орлогын татварын зардал	21,980,997.39	51,437,335.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	129,432,452.80	462,936,014.15

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	1,317,407,981.64	1,478,560,994.95
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(173,526,902.01)	(173,526,902.01)
03	Залруулсан үлдэгдэл	161,153,013.31	1,143,881,079.63	1,305,034,092.94
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	129,432,452.80	129,432,452.80
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	1,273,313,532.43	1,434,466,545.74
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(75,233,635.48)	(75,233,635.48)
11	Залруулсан үлдэгдэл	161,153,013.31	1,198,079,896.95	1,359,232,910.26
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	462,936,014.15	462,936,014.15
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	161,153,013.31	1,661,015,911.10	1,822,168,924.41

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,348,084,379.84	15,080,894,196.27
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,363,997,946.84	14,268,298,161.91
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	9,760,052.00	3,031,653.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	615,267,800.00	610,028,200.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	359,058,581.00	199,536,181.36
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,874,273,193.23	10,887,868,054.13
1.2.1	Ажиллагчдад төлсөн	925,020,249.77	1,456,105,702.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	274,974,145.21	379,111,233.22
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	88,784,737.00	40,303,087.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	46,404,436.00	33,253,046.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	31,415,000.00	14,889,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	803,138.07
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	348,463,820.74	1,178,428,121.49
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,837,110.00	45,056,155.08
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,157,373,694.51	7,739,918,570.35
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	473,811,186.61	4,193,026,142.14
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	11,753,151.69
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	11,753,151.69
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	121,372,500.00	130,264,225.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	121,372,500.00	130,264,225.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(121,372,500.00)	(118,511,073.31)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,144,972.15	874,060.46
3.1.4	Бусад	10,144,972.15	874,060.46
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	128,741,920.02	40,884,638.68
3.2.4	Төлсөн ногдол ашиг	120,635,530.00	40,881,620.00
3.2.5	Бусад	8,106,390.02	3,018.68
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(118,596,947.87)	(40,010,578.22)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	233,841,738.74	4,034,504,490.61
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	538,133,859.53	771,975,598.27
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	771,975,598.27	4,806,480,088.88

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мян.төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.1	Борлуулалтын орлого	2,624,581.7	12,452,939.1	(9,828,357.4)	474.5
1.2	Нийслэлийн төсвөөс	554,571.8	554,571.1	0.7	100.0
1	Нийт орлогын дүн	3,179,153.5	13,007,510.1	(9,828,356.6)	409.2
2.1	ББӨ	419,933.1	9,876,145.6	(9,456,212.5)	2,351.8
2.2	Цалин, нэмэгдэл	1,504,194.9	1,629,683.6	(125,488.6)	108.3
2.3	Хоол,унаа	174,510.0	149,330.0	25,180.0	85.6
2.4	НДШ	209,838.1	227,819.7	(17,981.5)	108.6
2.5	Түрээс, ашиглалт	50,000.0	47,604.4	2,395.6	95.2
2.6	Албан томилолтын зардал	60,500.0	59,073.2	1,426.8	97.6
2.7	Элэгдлийн зардал	91,082.2	97,516.6	(6,434.4)	107.1
2.8	Түүхий эд материалын зардал	71,598.6	107,773.9	(36,175.3)	150.5
2.9	2040 оны ЕТ-г УИХ-аар баталсны дараах танилцуулах, түгээхэд зарцуулах зардал	23,099.6	5,034.1	18,065.5	21.8
2.10.	Сургалтын зардал	62,020.0	21,149.3	40,870.7	34.1
2.11	Эрдэм шинжилгээ	63,573.0	59,123.7	4,449.3	93.0
2.12	Шуудан холбооны зардал	15,302.0	10,103.2	5,198.8	66.0
2.13	Тээврийн зардал	26,670.0	24,474.8	2,195.2	91.8
2.14	Засварын зардал	48,400.0	58,224.0	(9,824.0)	120.3
2.15	УЗ-н зардал	37,125.0	37,125.0	-	100.0
2	Үйл ажиллагааны зардал	2,857,846.5	12,410,180.9	(9,552,334.4)	434.2
3	Үйл ажиллагааны бус зардал	155,090.0	82,549.0	72,541.0	53.2
4	Нийт зардал	3,012,936.5	12,492,729.9	(9,479,793.4)	414.6
5	Татвар төлөхийн өмнөх ашиг	166,217.0	514,780.2	(348,563.2)	309.7
6	Татварын зардал	16,621.7	51,844.2	(35,222.5)	311.9
7	Цэвэр ашиг	149,595.3	462,936.0	(313,340.7)	309.5
8	БОНТНЗ	0.9	1.0	(0.0)	101.3
9.1	Авлага	619,655.4	790,298.8	(170,643.4)	127.5
9.2	Өглөг	167,023.7	4,123,792.3	(3,956,768.6)	2,469.0
10.2	Хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр/	131,768.5	128,939.4	2,829.1	97.9
11	Орон тоо	81.0	81.0	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь Нийслэл хотыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх зорилгоор бүс нутгийн хөгжлийн төсөл, Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын судалгаа, эрдэм шинжилгээний ажил, барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн зураг төсөл, авто зам гүүрийн зураг төсөл боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, зохиогчийн хяналт тавих ажлыг хэрэгжүүлдэг Нийслэлийн Засаг даргын харьяа мэргэжлийн байгууллага юм.

Тус ОНӨААТҮГ эрхэм зорилгоо “Түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн нийслэлийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг, төсөл боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж Хотын удирдлага, хот байгуулалтын салбарын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн эрдэм, шинжилгээ, судалгааны ажил, зураг төслөөр хангахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хот төлөвлөлтийн суурь судалгааг хийх, хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засаг нийгмийн зорилтод тусгагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрийн зураг төсөл болон бусад ТЭЗҮ, төсөл хөтөлбөр боловсруулах зэрэг үйл ажиллагааг эрхэлж байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Зохиогчдын эрх болон түүнийг хамгаалах эрхийн тухай хууль, Газрын тухай хууль, Авто замын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль.

ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг гүйцэтгэх захирлын 2023 оны А/22 тоот тушаалаар баталсан ба холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,198,522.0 мянган төгрөгөөр буюу 3.4 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө	771,975.6	4,806,480.1	4,034,504.5
Авлага	660,076.9	784,933.3	124,856.4
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	825.0	6,639.5	5,814.5
Бараа материал	55,593.2	57,758.2	2,165.0
Үндсэн хөрөнгө	257,284.3	287,692.0	30,407.7
Биет бус хөрөнгө	2,208.0	2,981.8	773.8
Нийт хөрөнгө	1,747,963.0	5,946,484.9	4,198,522.0
Өр төлбөр	313,496.4	4,123,792.3	3,810,295.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,434,466.6	1,822,692.6	388,226.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,747,963.0	5,946,484.9	4,198,522.0

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,806,480.1 мянган төгрөг болж, 4,034,504.5 мянган төгрөгөөр өссөн нь Сэлбэ сэргэлт төсөл болон бусад зураг төслийн ажлын хөлс оны эцэст орж ирсэнтэй;
- Авлага дансны үлдэгдэл 784,933.3 мянган төгрөг болж 124,856.4 мянган төгрөгөөр өссөн нь зураг төсөл боловсруулах ажлын барьцаа, тендерийн баталгаа, гэрээт ажлын үлдэгдэл, зохиогчийн хяналтын авлагууд 153,297.2 мянган төгрөгөөр буурч, татвар, НДШ-ийн авлага 278,153.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй;
- Бараа материал дансны үлдэгдэл 57,758.2 мянган төгрөг болж 2,165.0 мянган төгрөгөөр өссөн нь зураг төслийн ажилд шаардагдах принтер, каноны хор, цаас, бусад түүхий эд материалыг худалдаж авсантай;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 287,692.0 мянган төгрөг болж 30,407.7 мянган төгрөгөөр өссөн нь 128,284.2 мянган төгрөгийн компьютер, техник, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, 65,278.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 65,559.2 мянган төгрөгийн хөрөнгө аклан данснаас хасч, 97,595.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 4,123,792.3 мянган төгрөг болж 3,810,295.9 мянган төгрөгөөр өссөн нь нэр бүхий 19 харилцагчид өгөх 3,551,065.0 мянган төгрөгийн гэрээт ажлын төлбөрийн өглөг үссэн, 572,727.3 мянган төгрөгийн орлого урьдчилж орсонтой;
- Эздийн өмчийн дүн 1,822,692.6 мянган төгрөг болж 388,226.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүн 463,459.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх оны үр дүн рүү залруулсан зохиогчийн хяналт, барьцаатай холбоотой 34,352.0 мянган төгрөг, ногдол ашигт төвлөрүүлсэн 40,881.6 мянган төгрөгөөр буурсан өөрчлөлт орсонтой тус тус холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг Даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/688 дугаар захирамжаар “Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин”-г баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 3,179,153.5 мянган төгрөг, нийт зардлыг 3,029,558.2 мянган төгрөг, 149,595.3 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 131,768.5 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 13,007,510.1 мянга, бусад орлого 12,319.0 мянга нийт 13,019,829.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 12,504,873.9 мянган төгрөгийн зардал гарган, 514,955.2 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 13,019,829.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 9,840,675.6 мянган төгрөг буюу 309.5 хувиар давсан нь Нийслэлийн Засаг даргын А/492 дугаар захирамжийн дагуу 14,795,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхийн “Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам гүүрний тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэсэнтэй холбоотой байна. Энэхүү төслийн 20 хувь буюу 3,003,067.7 мянган төгрөгийн ажлыг тус ОНӨААТҮГ, 80

хувь буюу 11,792,732.3 мянган төгрөгийн ажлыг 6 туслан гүйцэтгэгч шууд гэрээгээр гүйцэтгэсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 12,504,873.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 9,475,315.7 мянган төгрөг буюу 312.8 хувийн илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь дээрх “Сэлбэ сэргэлт” төслийн зураг, төслийн ажлыг гүйцэтгэхтэй холбогдох зардал болон ажилчдын цалин хөлсийг нэмсэнтэй тус тус холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өөрийн эх үүсвэрээс 128,284.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 463,459.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 313,864.4 мянган төгрөгөөр давсан байна. НӨХГ-т ногдол ашигт 40,881.6 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгах, шилэн дансны хуулиудын хэрэгжилт, бараа ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аккаунт траст аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа, компанийн захирал П.Наранцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлангаа НТАГ-т 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/174 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 2,540,899.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 38,113.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тайлант онд нийт зардлын дүн өмнөх оноос материаллаг хэмжээгээр өөрчлөгдөн 12,494,278.8 мянган төгрөг болж 491.7 хувиар буюу 9,953,379.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Иймд гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2023 оны нийт зардлын 12,494,278.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 187,414.2 мянган төгрөгөөр тооцлоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажиллах төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. Албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээ болон erp.ulaanbaatar.mn цахим хэлбэрт шилжүүлэн ажилласнаар цаасан суурьтай бичиг баримтын зардал багассан,

түрээс, ашиглалтын зардлыг 2,395.6 мянга, сургалтын зардлыг 40,870.7 мянга, шуудан холбооны зардлыг 5,198.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх 6 мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв байршуулж, хэрэглэгчдийг ил тод мэдээллээр хангаж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ, тогтоомжийн хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд Нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөлдгүй шууд гэрээ байгуулан 7,021,229.1 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг 15 харилцагчаар гүйцэтгүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, ЗГ-ын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дугаар тогтоолын хавсралтад “Шууд худалдан авч болох бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг 20.0 сая төгрөг” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийслэлийн Засаг даргын А/492 дугаар захирамжаар 14,795,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхийн “Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам гүүрний тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу боловсруулж батлуулахыг Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ-т даалгасан байна. Энэхүү төслийн 20 хувь буюу 3,003,067.7 мянган төгрөгийн ажил нь тус ОНӨААТҮГ-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамаарч байгаа бөгөөд 80 хувь буюу 11,792,732.3 мянган төгрөгийн ажлыг 6 туслан гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Эдгээрээс 6,575,362.2 мянган төгрөгийн төлбөрийг тайлант онд төлж, зарим ажлын гүйцэтгэл, хяналттай холбоотойгоор 5,217,370.1 мянган төгрөгийн төлбөр дараа онд хийгдэхээр хүлээгдэж байна. Энэ асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн /Нийслэлийн засаг даргын/ нэгтгэсэн санхүүгийн тайланд хамруулан авч үзэх шаардлагатай байна.